



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 9/04

Эрдэнэт

**АЙМГИЙН 2018 ОНЫ  
ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.б дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2018 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

Д/д	Аймгийн нийт орлогын дүн	/мянган төгрөг/
<b>1</b>	<b>Урсгал орлого</b>	<b>82,409,439.4</b>
<b>1.1</b>	<b>Татварын орлого</b>	<b>43,800,884.8</b>
1.1.1	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	27,920,000.0
1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,250,000.0)
1.1.3	Үйл ажиллагааны орлого	240,000.0
1.1.4	Хөрөнгийн орлого	1,035,000.0
1.1.5	Хөрөнгө борлуулсны орлого	490,000.0
1.1.6	Шууд бус орлого	410,000.0
1.1.7	Бусад орлого	
1.1.8	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	6,032,584.8
1.1.9	Бууны албан татвар	18,000.0
1.1.10	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	710,000.0
1.1.11	Улсын тэмдэгтийн хураамж	350,000.0
1.1.12	Газрын төлбөр	8,300,000.0
1.1.13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	500,000.0
1.1.14	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19,300.0
1.1.15	Ус, рашаан ашигласны төлбөр	21,000.0
1.1.16	Ойн нөөц ашигласны төлбөр	5,000.0
<b>1.2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>634,478.7</b>
1.2.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	59,478.7
1.2.2	Хүү, торгуулийн орлого	575,000.0
<b>1.3</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>-</b>
1.3.1	Хөрөнгө борлуулсны орлого	
<b>1.4</b>	<b>Тусламжийн орлогын дүн</b>	<b>37,974,075.9</b>
1.4.1	Хандив тусламжийн орлого	
1.4.2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	
1.4.3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,504,918.8
1.4.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	34,220,533.8
1.4.5	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	248,623.3

**Хоёр.** Аймгийн 2018 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харъяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

		/мянган төгрөг/
<b>2.1</b>	<b>Засаг дарга</b>	<b>59,478.7</b>
2.1.1	Орон нутгийн өмчийн газар	55,978.7
2.1.2	Байгаль, орчин аялал жуулчлалын газар	1,500.0
2.1.3	Сум дундын ойн анги	2,000.0
<b>2.2</b>	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллага</b>	<b>248,623.3</b>
2.2.1	Ерөнхий боловсролын сургууль	198,435.2
2.2.2	Биеийн тамир спортын газар	15,000.0
2.2.3	Орон нутгийн музей	800.0
2.2.4	Орон нутгийн номын сан	2,981.4
2.2.5	Хүүхэд залуучуудын театр	24,819.1
2.2.6	Сумдын соёлын төв	6,587.6

**Гурав.** Аймгийн 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор, дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

		/мянган төгрөг/
<b>3.1</b>	<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</b>	<b>820,408.5</b>
3.1.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	820,408.5
<b>3.2</b>	<b>Засаг дарга</b>	<b>17,483,552.9</b>
3.2.1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	1,861,408.9
3.2.2	Хотын захирагчийн алба	149,819.1
3.2.3	Хот тохижуулах газар	2,135,820.3
3.2.4	Орон нутгийн өмчийн газар	211,343.6
3.2.5	Ахмад настны байгууллагад орон нутгаас олгох санхүүжилт	64,445.0
3.2.6	Аймгийн халамжийн сан	9,864,716.9
3.2.7	Байгаль, орчин аялал жуулчлалын газар	146,315.8
3.2.8	Сум дундын ойн анги	52,883.6
3.2.9	Санхүүгийн хяналт, аудитын алба	112,175.3
3.2.10	Нийтлэг үйлчилгээний алба	364,691.8
3.2.11	Жолоочийн хариуцлагын даатгалын санд олгох шилжүүлэг	71,000.0
3.2.12	Хотын нийтийн тээврийн хөнгөлөлт	845,889.3
3.2.13	Баян-Өндөр суманд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	1,122,130.3
3.2.14	Жаргалант суманд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	480,913.0

**Дөрөв.** Аймгийн 2018 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зардлын хэмжээг **18.3 тэрбум төгрөгөөр** баталсугай.

		/мянган төгрөг/
<b>№</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>14,114,602.3</b>
5.1	<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	<b>12,722,808.2</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардал	8,700,425.0
	Төсөл, хөтөлбөрийн зардал	4,022,383.2
5.2	<b>Автозамын сан</b>	<b>639,000.0</b>
5.3	<b>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал</b>	<b>752,794.1</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардал	283,510.0
	Төсөл, хөтөлбөрийн зардал	469,284.1

**Тав.** Аймгийн 2018 оны төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засвар, төсөл арга хэмжээний зардлын дээд хэмжээг **14.1 тэрбум төгрөгөөр** баталсугай.

**Зургаа.** Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.



		/мянган төгрөг/
<b>№</b>	<b>ОНХС-аас олгох аймаг, сум</b>	<b>3,504,918.8</b>
6.1	<b>Аймаг</b>	<b>1,968,813.5</b>
	Үүнээс: Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зардал	1,545,096.2
	Хот тохижуулах газрын урсгал зардал	384,832.9
	Мал эмнэлгийн үйлчилгээний урсгал зардал	38,884.4
6.2	<b>Жаргалант сум</b>	<b>752,478.1</b>
6.3	<b>Баян-Өндөр сум</b>	<b>783,627.2</b>

**Долоо.** Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зардлыг дор дурдсанаар баталсугай.

		/мянган төгрөг/
	<b>Байгууллагын нэр</b>	<b>34,469,157.1</b>
7.1	ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ	12,242,235.9
7.2	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	18,658,171.8
7.3	СУМЫН ЭМНЭЛЭГ	316,440.5
7.4	БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР	282,911.0
7.5	ОРОН НУТГИЙН МУЗЕЙ	102,358.5
7.6	ОРОН НУТГИЙН НОМЫН САН	227,270.1
7.7	ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ТЕАТР	396,686.8
7.8	СУМДЫН СОЁЛЫН ТӨВ	293,094.1
7.9	ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР	288,251.2
7.10	ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС	244,379.3
7.11	ӨРХИЙН ЭМНЭЛЭГ	1,417,358.1

**Найм.** 2018 оны төсвийн жилд улсын төсөвт тэгшитгэн төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

		/мянган төгрөг/
<b>№</b>	<b>Зардлын төрөл</b>	
1	Улсын төсөвт төвлөрүүлэх	12,016,799.8
<b>Нийт дүн</b>		<b>12,016,799.8</b>

**Ес.** Аймгийн 2018 оны төсвийн суурь зардлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**Арав.** Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын 2018 оны төсвийн зарлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Арван нэг.** Аймгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2018 оны жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

**Арван хоёр.** Аймгийн байгаль орчныг хамгаалах төсөл арга хэмжээний 2018 оны жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

**Арван гурав.** Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг тавдугаар хавсралтаар баталсугай.

**Арван дөрөв.** Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг зургаадугаар хавсралтын ёсоор баталсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА